



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 11-129

Улаанбаатар хот

**Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм”-ийн 2.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг нийт албан хаагчдад чанд мөрдүүлэн, зөвлөлийн ажлын төлөвлөгөө, тайлан, дүгнэлтийг цаг тухайд нь танилцуулан, холбогдох байгууллагад мэдээлж ажиллахыг Ёс зүйн зөвлөл (Н.Мөнхбаатар)-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2019 оны А/304 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА  М.БАЯРАА



Тушаал2021

115050000376

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2021 оны 05 дугаар сарын
07-ний өдрийн 01/09 тушаалын нэгдүгээр хавсралт



Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн

Ёс зүйн зөвлөлийн дарга: Орлогч дарга /Захиргааны асуудал хариуцсан/


Гишүүд: Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн дарга

Хуулийн мэргэжилтэн

Зөвлөлийн нарийн бичгийн дарга: Захиргаа санхүүгийн хэлтсийн ахлах, хүний нөөцийн мэргэжилтэн

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 17
-ны өдрийн 21/129 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн зорилго нь төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэх, төрийн албан хаагчдын мэргэжлийн ёс зүйг мөрдөж, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, аливаа зөрчил, гажуудлаас сэргийлэхэд оршино.

1.3. Байгууллагын Ёс зүйн зөвлөл нь нийт ажиллагсдын саналаар сонгогдсон, ажиллагсдын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий байнгын ажиллагаатай орон тооны бус байна.

1.4. Зөвлөлийн үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актуудын хүрээнд явагдана.

1.5. Зөвлөл нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, тэгш байдал, шударга ёсыг баримтлах, нууцыг хадгалах, хараат бус байх зарчмуудыг баримтална.

1.6. Зөвлөл нь ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчийг газрын дарга, орлогч дарга, шууд харьяалах нэгжийн дарга нарын санал, мэдээллийн мөрөөр асуудлыг хэлэлцэнэ.

1.7. Зөвлөлийн шийдвэрийг байгууллагын ажиллагсад дагаж мөрдөнө.

Хоёр. Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн эрх үүрэг

2.1. Төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах

2.2. Гомдол, мэдээлэлд холбогдох төрийн албан хаагч болон түүний харьяалах төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гомдол мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдний тайлбар, саналыг сонсох, холбогдох нотолгоо, материал, баримт бичгийг шаардан авах

2.3. Гомдол, мэдээллийн нууцлалыг хадгалах, шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээлэл гаргагчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авахуулахаар холбогдох байгууллагад хандах

2.4. Гомдол, мэдээллийг хуралдаанаараа хэлэлцэж, шалгасан тухай дүнг гишүүдийн олонхийн саналаар дүгнэлт өгөх

2.5. Гомдол, мэдээллээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийн мөрөөр, түүнчлэн өөрийн санаачлагаар болон байгууллагын удирдлагын шийдвэрээр ёс зүйн зөрчлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах

2.6. Байгууллагын Ёс зүйн зөвлөл нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тухай мэдээг улирал тутам гаргаж, тухайн улирлын дараа сарын 10-ны дотор Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн зөвлөлд хүргүүлнэ. Жилийн эцсийн тайланг өссөн дүнгээр гарган салбар зөвлөлийн жилийн ажлын тайлангийн хамт файлаар болон цаасаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлнэ.

Гурав. Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн дүгнэлт

3.1. Байгууллагын Ёс зүйн зөвлөл дүгнэлтээ эрх бүхий албан тушаалтанд (байгууллагын даргад) танилцуулна.

3.2. Эрх бүхий албан тушаалтан нь Ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг хянаж үзээд дараах үндэслэлээр дахин шалгуулахаар Ёс зүйн зөвлөлд буцаах шийдвэр гаргаж болно. Үүнд:

- Ёс зүйн зөрчил гаргасан нотолгоо, баримт бичгийн бүрдэл хангагдаагүй.
- Холбогдох нотолгоо, баримт бичиг, материалыг шалгаагүй буюу хангалтгүй шалгасан.

3.3. Байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан (дарга) нь Ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийн дагуу тухайн төрийн албан хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэх шаардлагагүй гэж үзвэл энэ тухай үндэслэл бүхий шийдвэр гаргаж, холбогдох талуудад мэдэгдэнэ.

3.4. Төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасныг тогтоож, сахилгын шийтгэл ногдуулахаар гаргасан байгууллагын Ёс зүйн зөвлөлийн дүгнэлт, байгууллагын удирдлагын саналыг Төрийн албаны зөвлөлд холбогдох баримт, материалын хамт хүргүүлнэ.